



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Өгийнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/66/-НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Архангай аймаг

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn

Аудитор П.Цэцэгдулам

Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	
1.Аудитын тайлан.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	11
<b>3.1 Ерөнхий зүйл.....</b>	<b>11</b>
<b>3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....</b>	<b>11</b>
<b>3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....</b>	<b>12</b>
<b>3.4 Материаллаг байдал .....</b>	<b>12</b>
<b>3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....</b>	<b>13</b>
<b>3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....</b>	<b>14</b>
<b>3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....</b>	<b>15</b>
<b>3.8 Аудитын гол асуудал.....</b>	<b>15</b>
<b>3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....</b>	<b>15</b>
<b>3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....</b>	<b>16</b>
<b>3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....</b>	<b>16</b>
<b>3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....</b>	<b>16</b>
<b>3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....</b>	<b>16</b>
4. Аудитын илрүүлэлт .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

## 1. Аудитын тайлан

 <b>АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 65130 Цэцэрлэг, Архангай аймаг Утас/Факс: 976-70333141 И-мэйл: arkhangai@audit.gov.mn	<b>ӨГИЙНУУР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Д.ГАЛБАДРАХ ТАНАА</b>
<u>2021.02.28</u> № <u>92</u> танай _____ -ны № _____ -г	
<b>АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ</b>	
<b>Зөрчилгүй дүгнэлт</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өгийнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Өгийнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
<b>Дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
<b>Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага</b>	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p> <p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.</p>	
<b>Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага</b>	
<p>Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.</p> <p>Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.</p> <p>Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.</p>	
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	 Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	52,624,658.50	151,663,105.19
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	346,926.09
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	346,926.09
31210	Төгрөг	0.00	346,926.09
31211	Төрийн сангийн харилцах	0.00	330,047.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	16,879.09
33	АВЛАГА	0.00	32,440,200.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	32,440,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	52,624,658.50	118,875,979.10
35100	Түүхий эд материал	25,926,836.55	94,119,269.84
35130	Эм боох материал	25,926,836.55	94,119,269.84
35400	Хангамжийн материал	25,097,821.95	24,756,709.26
35410	Бичиг хэргийн материал	1,407,150.00	1,299,300.00
35420	Аж ахуйн материал	23,359,093.95	23,457,409.26
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	563,665,329.89	638,559,891.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	563,665,329.89	638,559,891.02
39200	Биет хөрөнгө	542,369,329.89	617,623,891.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	487,342,088.68	487,342,088.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,500,153.07	-36,085,244.07
39203	Авто-тээврийн хэрэгсэл	43,203,994.00	115,603,994.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-20,481,717.08	-22,604,845.88
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	73,580,981.24	100,214,455.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	-42,691,055.91	-38,835,056.77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	73,116,715.12	67,280,036.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-63,151,523.01	-60,541,536.79
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,050,000.08	-4,750,000.12
39300	Биет бус хөрөнгө	21,296,000.00	20,936,000.00
39301	Програм хангамж	1,800,000.00	1,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-660,000.00	-1,020,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,156,000.00	20,156,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	616,289,988.39	790,222,996.21
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	45,660,474.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	45,660,474.00
41300	Өглөг	0.00	45,660,474.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	45,660,474.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	616,289,988.39	744,562,522.21
51	Засгийн газрын хувь оролцоо	616,289,988.39	744,562,522.21
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	527,154,798.11	527,154,798.11
51200	Хуримтлагдсан үр дүн	65,939,528.13	195,738,624.99
51210	Өмнөх үеийн үр дүн	-294,751,537.21	67,466,091.17
51220	Тайлант үеийн үр дүн	360,691,065.34	128,272,533.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	23,195,662.15	21,669,099.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	616,289,988.39	790,222,996.21

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	909,286,817.91	1,107,980,934.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	423,984,381.91	354,517,654.59
120	Нийтлэг татварын бус орлого	423,984,381.91	354,517,654.59
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	382,796,270.00	110,134,221.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	41,188,111.91	244,383,433.03
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	485,302,436.00	753,463,280.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	426,723,100.00	478,099,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	426,723,100.00	478,099,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,942,736.00	224,515,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,168,700.00	157,075,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,774,036.00	35,000,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	32,440,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	17,695,700.00	18,850,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,695,700.00	18,850,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	32,940,900.00	31,998,180.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,940,900.00	31,998,180.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	548,595,752.57	979,708,400.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	548,595,752.57	979,708,400.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	548,572,282.57	944,708,400.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	325,312,476.00	421,472,990.30
210101	Үндсэн цалин	199,400,000.00	206,626,723.00
210102	Нэмэгдэл	99,562,476.00	148,165,264.30
210104	Урамшуулал	19,750,000.00	35,520,760.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	31,160,243.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,952,160.00	56,389,185.61
210201	Тэтгэврийн даатгал	31,200,160.00	41,243,200.63
210202	Тэтгэмжийн даатгал	3,188,000.00	3,817,170.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,550,400.00	3,046,476.50
210204	Ажилгүйдлийн даатгал	637,600.00	747,636.91
210205	Эрүүл мэндийн даатгал	6,376,000.00	7,534,700.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,030,952.00	17,238,992.00
210301	Гэрэл, цахилгаан	4,394,482.00	5,055,482.00
210302	Түлш, халаалт	15,636,470.00	11,183,510.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,079,945.00	38,584,785.18
210401	Бичиг хэрэг	5,856,130.00	4,392,000.00

210402	Тээвэр, шатахуун	14,688,300.00	19,981,710.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800.00	1,460,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	410,250.00	2,892,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,618,465.00	8,259,075.18
210408	Бараа материал акталсны зардал	1,200,000.00	1,600,000.00
2105	Нормативт зардал	51,777,460.26	364,059,770.25
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44,244,111.26	346,305,517.25
210502	Хоол, хүнс	7,533,349.00	16,434,253.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	1,320,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	788,000.00	1,600,000.00
210604	Урсгал засвар	788,000.00	1,600,000.00
2107	Томилолт, зочны зардал	890,000.00	566,000.00
210702	Дотоод албан томилолт	890,000.00	566,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,839,056.00	581,817.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,656.00	111,817.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	457,500.00	220,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,902,233.31	44,214,860.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,331,100.00	1,561,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,571,133.31	42,653,360.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,470.00	35,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	35,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	35,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	360,691,065.34	128,272,533.82
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	360,691,065.34	128,272,533.82

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	527,154,798.11	88,732,481.15	-360,288,356.21	255,598,923.05
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	65,536,819.00	65,536,819.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	527,154,798.11	88,732,481.15	-294,751,537.21	321,135,742.05

4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-	0.00	-65,536,819.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	360,691,065.34	360,691,065.34
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	527,154,798.11	23,195,662.15	65,939,528.13	616,289,988.39
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	527,154,798.11	23,195,662.15	65,939,528.13	616,289,988.39
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,526,563.04	1,526,563.04
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	527,154,798.11	23,195,662.15	67,466,091.17	617,816,551.43
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-1,526,563.04	0.00	-1,526,563.04
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	128,272,533.82	128,272,533.82
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	527,154,798.11	21,669,099.11	195,738,624.99	744,562,522.21

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>485,302,436.00</b>	<b>721,023,080.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>485,302,436.00</b>	<b>721,023,080.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>426,723,100.00</b>	<b>478,099,900.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	426,723,100.00	478,099,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,942,736.00</b>	<b>192,075,000.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,168,700.00	157,075,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,774,036.00	35,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>17,695,700.00</b>	<b>18,850,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,695,700.00	18,850,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>32,940,900.00</b>	<b>31,998,180.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,940,900.00	31,998,180.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>483,104,936.00</b>	<b>713,262,453.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>483,104,936.00</b>	<b>713,262,453.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>483,081,466.00</b>	<b>678,262,453.91</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>325,312,476.00</b>	<b>421,472,990.30</b>
210101	Үндсэн цалин	199,400,000.00	206,626,723.00
210102	Нэмэгдэл	99,562,476.00	148,165,264.30
210104	Урамшуулал	19,750,000.00	35,520,760.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	31,160,243.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>43,952,160.00</b>	<b>56,389,185.61</b>
210201	Тэтгэврийн даатгал	31,200,160.00	41,243,200.63
210202	Тэтгэмжийн даатгал	3,188,000.00	3,817,170.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,550,400.00	3,046,476.50
210204	Ажилгүйдлийн даатгал	637,600.00	747,636.91

210205	Эрүүл мэндийн даатгал	6,376,000.00	7,534,700.96
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,006,282.00</b>	<b>17,250,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,394,482.00	5,055,482.00
210302	Түлш, халаалт	11,550,000.00	11,183,510.00
210303	Цэвэр, бохир ус	61,800.00	1,011,008.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,215,550.00</b>	<b>33,232,110.00</b>
210401	Бичиг хэрэг	2,290,450.00	2,671,700.00
210402	Тээвэр, шатахуун	13,668,300.00	19,981,710.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800.00	1,460,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	3,122,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,450,000.00	5,996,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>32,930,992.00</b>	<b>142,531,151.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,381,300.00	125,767,789.00
210502	Хоол, хүнс	6,509,892.00	15,443,362.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,039,800.00	1,320,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,689,000.00</b>	<b>3,082,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	155,000.00
210604	Урсгал засвар	1,689,000.00	2,927,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>890,000.00</b>	<b>566,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	890,000.00	566,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>35,982,556.00</b>	<b>581,817.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,656.00	111,817.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	457,500.00	220,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,102,450.00</b>	<b>3,157,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,102,450.00	3,157,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,470.00</b>	<b>35,000,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>35,000,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	35,000,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>2,197,500.00</b>	<b>7,760,626.09</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>2,197,500.00</b>	<b>7,413,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,197,500.00</b>	<b>7,413,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,197,500.00</b>	<b>7,413,700.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,197,500.00	7,413,700.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-2,197,500.00</b>	<b>-7,413,700.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0.00</b>	<b>346,926.09</b>
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	346,926.09

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	530,155,900.00	528,618,033.00	1,537,867.00	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	530,155,900.00	528,618,033.00	1,537,867.00	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	530,155,900.00	528,618,033.00	1,537,867.00	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	378,186,300.00	378,182,113.00	4,187.00	100.0
210101	Үндсэн цалин	199,872,000.00	206,626,723.00	-6,754,723.00	103.4
210102	Нэмэгдэл	106,448,000.00	104,874,387.00	1,573,613.00	98.5
210104	Урамшуулал	38,386,000.00	35,520,760.00	2,865,240.00	92.5
210105	Гэрээт ажлын хөлс	33,480,300.00	31,160,243.00	2,320,057.00	93.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,734,800.00	50,408,940.00	325,860.00	99.4
210201	Тэтгэврийн даатгал	35,702,400.00	35,262,955.02	439,444.98	98.8
210202	Тэтгэмжийн даатгал	3,758,100.00	3,817,170.61	-59,070.61	101.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,006,400.00	3,046,476.50	-40,076.50	101.3
210204	Ажилгүйдлийн даатгал	751,600.00	747,636.91	3,963.09	99.5
210205	Эрүүл мэндийн даатгал	7,516,300.00	7,534,700.96	-18,400.96	100.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,250,000.00	17,250,000.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	5,500,000.00	5,055,482.00	444,518.00	91.9
210302	Түлш, халаалт	11,200,000.00	11,183,510.00	16,490.00	99.9
210303	Цэвэр, бохир ус	550,000.00	1,011,008.00	-461,008.00	183.8
2104	Хангамж, бараа материалын зардал	26,248,800.00	26,248,800.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	2,642,000.00	2,571,700.00	70,300.00	97.3
210402	Тээвэр, шатахуун	16,700,000.00	16,700,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800.00	1,425,000.00	-118,200.00	109.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,539,900.00	-39,900.00	102.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,100,000.00	4,012,200.00	87,800.00	97.9
2105	Нормативт зардал	44,783,000.00	43,663,363.00	1,119,637.00	97.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	34,883,000.00	34,874,008.00	8,992.00	100.0
210502	Хоол, хүнс	7,500,000.00	7,469,355.00	30,645.00	99.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,400,000.00	1,320,000.00	1,080,000.00	55.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,559,800.00	8,559,800.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,959,800.00	6,959,800.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,600,000.00	1,600,000.00	0.00	100.0
2107	Томилот, зочны зардал	566,000.00	566,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилот	566,000.00	566,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	670,000.00	581,817.00	88,183.00	86.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	111,817.00	8,183.00	93.2

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	220,000.00	220,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,157,200.00	3,157,200.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,157,200.00	3,157,200.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	530,155,900.00	528,948,080.00	1,207,820.00	99.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	478,099,900.00	478,099,900.00	0.00	100.0
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	478,099,900.00	478,099,900.00	0.00	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,850,000.00	18,850,000.00	0.00	100.0
320001	Орон нутгийн төсвөөс	18,850,000.00	18,850,000.00	0.00	100.0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,206,000.00	31,998,180.00	1,207,820.00	96.4
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	33,206,000.00	31,998,180.00	1,207,820.00	96.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	330,047.00	-330,047.00	#DIV/0!
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	38,013.00	51.00	37,962.00	0.1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00	0.00	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19.00	19.00	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00	0.00	100.0

## 2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	192,058,120.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	192,058,120.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	157,058,120.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,290,877.30
210102	Нэмэгдэл	43,290,877.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,980,245.61
210201	Тэтгэврийн даатгал	5,980,245.61
2104	Хангамж, бараа материалын зардал	6,983,310.00
210401	Бичиг хэрэг	100,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,281,710.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	35,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,582,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,983,900.00
2105	Нормативт зардал	98,867,788.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	90,893,781.00
210502	Хоол, хүнс	7,974,007.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,935,900.00

Өгийнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	608,900.00
210604	Урсгал засвар	1,327,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	35,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	192,075,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	192,075,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	157,075,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,000,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,879.09

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өгийнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Алтанчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Өгийнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өгийнуур сумын Эрүүл мэндийн төв нь нийгмийн болон эмнэлгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага байна.

Тус байгууллага нь “Хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг ээлтэй орчинд жигд хүртээмжтэй шуурхай чанартай үзүүлж эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах үйл ажиллагааг өргөжүүлэн амьдралын чанарыг сайжруулах зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Үйлчлэх хүрээний хүн амд үзүүлэх хяналтын тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах.
2. Удирдлагын төлөвлөлт хүний нөөцийн чадавхыг сайжруулах үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх.
3. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж үр дүнг сайжруулж үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-иар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 67/А/268 дугаар тушаал “Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай”
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/585 дугаар тушаал “Мөнгөн тэтгэмж олгох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Өгийнуур сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурель сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 530.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 3.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 174.0 сая төгрөгөөр өссөн бөгөөд материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	Хувь
1	2	3	4=3-2	
Мөнгөн хөрөнгө	0	0.34	0.34	100.00
Авлага		32.4	32.4	100.00
Бараа материал	52.6	18.9	-33.7	-178.31
Үндсэн хөрөнгө	563.6	638.5	74.9	11.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>616.2</b>	<b>790.2</b>	174	22.02
<b>Өр төлбөр</b>		<b>45.6</b>	45.6	100.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	616.2	744.5	128.3	17.23
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>616.2</b>	<b>790.2</b>	174.0	22.02

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд 0.3 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлдэг болсонтой холбоотой байна.
- Авлагын дансны үлдэгдэл тайлант онд 32.4 сая төгрөгөөр өссөн нь ЭМДС-аас авах ковидын цогц тусламж үйлчилгээний санхүүжилт нэхэмжилснээс дутуу ирсэнтэй холбоотой байа.
- Бараа материал эхний үлдэгдлээс 33.7 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 52.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 232.4 сая төгрөг, хандиваар 244.3 сая төгрөг нийт 476.8 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 410.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 118.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 15.1 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 563.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 7.4 сая төгрөг, хандиваар 110.1 сая төгрөг нийт 117.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 42.6 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч 638.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 128.3 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	424	354.5	-69.5
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	426.7	478.1	51.4
Нэмэлт санхүүжилт	7.9	224.5	216.6
Орон нутгийн төсвөөс	17.7	18.8	1.1
Эрүүл мэндийн даатгалын сангаас	32.9	32	-0.9
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>909.2</b>	<b>1107.9</b>	198.7

Бараа ажил үйлчилгээний зардал	548.5	944.7	396.2
Урсгал шилжүүлэг	0.02	35	34.98
Хөрөнгийн зардал			0
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>548.52</b>	<b>979.7</b>	<b>431.18</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-360.68</b>	<b>-128.2</b>	<b>232.48</b>

Өгийнуур сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 198.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгож байгаатай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 546.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 16.7 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 530.1 сая төгрөгөөр хянаж баталсан бол тодотголоор батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 530.1 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1.2 сая төгрөгийн санхүүжилт Эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу ирсэн байна. Тайлант онд 528.6 сая төгрөгийг зарцуулж, 0.3 сая төгрөгийг мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМДС-аас ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилт 156.6 сая төгрөг, Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг урамшуулах зорилгоор олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 35.0 сая төгрөг, Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос сорьц тээвэрлэх зардалд 0.4 сая төгрөг нийт 192.1 сая төгрөг ирсэн байна. Ирсэн санхүүжилтийг зарцуулах эрхийн хүсэлт нээлгэн зарцуулсан байна. Үүнд: цалин шимтгэлд 49.3 сая, бичиг хэрэгт 0.1 сая, тээвэр шатахуунд 3.2 сая, хог хаягдалд 1.6 сая, эм

эмнэлгийн хэрэгслийн зардалд 99.0 сая, БҮТЭЗ-д 2.0 сая, хоол хүнсний зардалд 8.0 сая, урсгал завсрын зардалд 2.0 сая, мөнгөн тэтгэмжид 35.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Өгийнуур сумын Эрүүл мэндийн төв нь тайлант жилд ковид-19 халдварын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг нийт 428 хүнд үзүүлж ЭМДС-аас 65.6 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилж гүйцэтгэлээр 33.0 сая төгрөг авч оны эцэст 32.4 сая төгрөгийн авлагатай тайлагнасан.

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлж 0.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй үлдэгдлээр тайлагнасан бол ЭМГ-ын даргын 2021.08.25-ны өдрийн 02/849 дугаар тушаалын дагуу 94.1 сая төгрөгийн эмийн нөөцийг бүрдүүлж 45.6 сая төгрөгийн өр төлбөртэй байна.

Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн ажилтнуудад нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 35.0 сая төгрөг олгосон байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 89 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 96.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 530.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 99.7 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэлэхэд Үүнд:

- Тус байгууллага нь тайлант онд 7.3 сая төгрөгийн бараа материал, 5.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламжаар авч тайланд бүрэн тусгасан байна.
- Тус байгууллага нь үндсэн орон тооны жолоочтой бөгөөд цалингийн зардалд 12.0 сая төгрөг олгосон байна. Тайлант онд ЭМЯ-аас 43.0 сая төгрөгийн өртөгтэй УАЗ-фургон авто машин, аймгийн ОНХС-аас 35.0 сая төгрөгийн өртөгтэй TOYOTA Hiacc авто машин хандиваараа ирснийг бүртгэл тайланд тусгасан бөгөөд шатахууны жилийн зардалд 20.0 сая төгрөг, сэлбэгийн зардалд 1.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа. /Local.audit.mn сайтад шивсэн/

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өгийнуур сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд оруулбал зохих 144 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлж, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан тушаал, шийдвэрийг бүрэн байршуулсан байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд дотоод хяналт болон элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгөтэй холбоотой 2 заалт зөвлөмж өгч биелэлтийг бүрэн хангуулсан.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

ЭМС-аас авч буй санхүүжилтийг үнэн зөв тооцоолж байгаа эсэх

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 45.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснийг материаллаг бус гэж үнэлж албан шаардлага хүргүүлэн Зөрчилгүй дүгнэлт өглөө.

##### 4.1 Албан шаардлага

Өгийнуур сумын ЭМТ нь 32.4 сая төгрөгийн ЭМДС-аас авах авлага, 45.6 сая төгрөгийн эмийн өглөгтэй байна. Тооцоо нийлсэн актыг тулган шалгахад Өгий хишиг хоршоонд 0.6 сая төгрөг, ЭНТО ХХК-д 14.7 сая төгрөг, Монос-Архангай ХХК-д 0.4 сая төгрөг, Ази фарм ХХК-д 29.7 сая төгрөгийн тус тус өртэй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” гэсэн заалтын дагуу өр, авлагаа барагдуулах албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo-----

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Өгийнуур сумын ЭМТ	1	45.6					1	45.6		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Өгийнуур сумын ЭМТ	1	0	0	0	0	0	0	0	1	0
<b>Нийт дүн</b>		<b>2</b>	<b>45.6</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>